

**БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД**

С.БЯМБАЦОГТ

**СОГТУУРЧ, МАНСУУРЧ ДОНТОХ ӨВЧТЭЙ
ХҮНИЙГ АЛБАДАН ЭМЧЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улсад 1961 оноос эхлэн архинд донтох өвчтэй иргэдийг албадан эмчилж эхэлсэн бөгөөд албадан эмчлэх байгууллага нь 2000 он хүртэл цагдаа, хорих, эрүүл мэндийн байгууллагын харьяанд тус тус байсан байна.

Согтуурах, мансуурах донтой, өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хууль 2000 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр батлагдсан.

Энэхүү хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2000 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 148 дугаар тогтоол гарч, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа Багахангай дүүрэг дэх Архинд донтох өвчтөнг албадан эмчлэх эмнэлгийг Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын харьяанд шилжүүлж, “Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар” болгон зохион байгуулжээ.

Тус газар нь энэ хугацаанд үйл ажиллагаагаа тогтвортой явуулж, нийгэмд тулгамдаж буй асуудал болох согтуурах донтой хүнийг албадан эмчлэхэд ахиц гарган ажиллаж байна.

Согтуурах, мансуурах донтой, өвчтэй этгээдийг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газраас эмчлүүлэгчдийн судалгааг сүүлийн 10 жилээр гаргаснаас үзэхэд нэг жилд эмчлүүлэгчдийн тоо 290-ээс 1040-ийн хооронд хэлбэлзэж байна.

УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д архидан согтууралт, мансууралтай тэмцэх ажлыг эрчимжүүлж, хүн амын удмын санд учрах сөрөг нөлөөллийг бууруулах асуудлыг тэргүүлэх чиглэл болгон тодорхойлсон.

Хүн ам, удмын сангийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, архидан согтуурахтай тэмцэх ажлын хүрээнд тодорхой үүрэг гүйцэтгэж байгаа Согтуурах, мансуурах донтой, өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын үйл ажиллагааг боловсронгуй болгоход юуны түрүүнд даган мөрдөж буй хууль тогтоомжийг боловсронгуй болгох зүй ёсны шаардлага тавигдаж байна.

Түүнчлэн Албадан хөдөлмөрийн тухай 29 дүгээр конвенци болон Албадан хөдөлмөрийг устгах тухай 105 дугаар конвенцид Монгол Улс 2005 онд нэгдэн орсон. Эдгээр конвенцид хуулийн заалтыг нийцүүлэх, нөгөө талаар

согтуурах донтой өвчтэй хүнийг албадан эмчлэхийн хажуугаар албадан хөдөлмөр хийлгэх нь эмчилгээний горимд харшлах учир хуульд заасан албадан хөдөлмөр хийлгэх зохицуулалтыг өөрчлөх шаардлагатай байна.

Хуулийн төсөл боловсруулахдаа энэ чиглэлээр хийгдсэн судалгааны материал болон бусад орны хууль тогтоомжийг судалж, харьцуулалт хийнэ.

Хоёр.Хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ, хуулийн төслийн ерөнхий бүтэц

Согтуурах, мансуурах донтой, өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын үйл ажиллагаанд тулгамдаж байгаа болон хуульд заасан боловч хэрэгжих боломжгүй байгаа зарим асуудлыг шийдвэрлэх зорилгоор Согтуурах, мансуурах донтой, өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуульд оруулж байгаа нэмэлт, өөрчлөлтийн цар хүрээг харгалзан хуулийн төслийг шинэчилсэн найруулгын төсөл хэлбэрээр боловсруулна.

Хуульд орох өөрчлөлттэй уялдуулан хуулийн нэрнээс албадан хөдөлмөр хийлгэх гэснийг хасна.

Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд өвчтэй хүний эмнэлгийн тусламж авах эрхээ эдлэх нөхцөл боломжийг сайжруулах, албадан эмчлэх мэргэжлийн удирдлагыг тавигдаж байгаа шаардлагын түвшинд хүргэх хэрэгцээ, шаардлагыг харгалзан энэ чиглэлээр эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хэрэгжүүлэх ёстой чиг үүргийг тодорхой заана.

Албадан эмчлэх хугацаа нь өвчтөний биеийн байдал, эмчилгээний явцаас хамаарах учир хуулийн төсөлд эмчлэх хугацааны доод хязгаарыг заана.

Зайлшгүй шаардлагатай зарим зардлын эх үүсвэрийг, тухайлбал эмчилгээнд ирсэн өвчтөний суурь өвчнийг оношлох, эмчлэх зардал, өвчтөний эмчилгээний хоол, хувцасны болон эмнэлгээс гарсан өвчтөн буцах замын зардал зэргийг Албадан эмчлэх газрын зардалд тооцож оруулахаар заана.

Хуульд мансуурах донтой өвчтэй этгээдийг эмчилгээнд хамруулахаар заасан ба өнгөрсөн хугацаанд мансуурах донтой өвчтэй хүн эмчлүүлэхээр ирж байгаагүй боловч ийм өвчтэй хүнийг эмчилгээнд хамруулах хэрэгцээ байгааг харгалзан мансуурах донтой, өвчтэй этгээдийг эмчлэх үндэслэлийг хуульд хэвээр үлдээнэ.

Хуульд байгууллага, албан хаагчдын хэрэгжүүлэх үйл ажиллагаа эрх хэмжээний талаар заасан бөгөөд харин албадан эмчлүүлэгчийн эрх, үүргийн талаар дурдаагүй. Иймээс хуулийн төсөлд албадан эмчлүүлж буй хүний эрх, үүргийн тухай зүйл, заалт нэмнэ.

Тухайн хүнийг албадан эмчилгээнд явуулах хүсэлт гаргахаас эхлээд бүх ажиллагааны явцад хүний эрхийг зөрчихгүй байх нөхцөл бүрдүүлэх үүднээс

согтуурах, мансуурах донтой өвчтэй эсэх тухай үзлэг, шинжилгээ хийж, эмнэлгийн дүгнэлт гаргах, албадан эмчлэх шийдвэр гаргах ажиллагаа, албадан эмчлэх газарт хүлээж авах тухай зүйл, заалтыг илүү нарийвчлан тусгана.

Албадан эмчлэх газарт эмчлүүлээд гарсан хүний асуудлыг хэрхэн анхаарах талаар зохицуулалт нэмнэ.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засгийн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөлд шаардлагатай байгаа зарим зардлын эх үүсвэрийг шийдэх чиглэлээр зохицуулалт нэмэх тул хуулийн төсөл батлагдсаны дараа хэрэгжүүлэх явцад нэмэлт хөрөнгө, зардал шаардагдах болно. Нэмэлт зардлын тооцоог тусгайлан гаргаж хавсаргана.

Дөрөв.Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Согтуурч, мансуурч донтох өвчтэй хүнийг албадан эмчлэх тухай хуулийн төсөлтэй холбогдох бусад хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулна.

-----oO-----